



GRATA
INTERNATIONAL

Хуулийн этгээд татан буугдах үйл ажиллагаа

GRATA International Mongolia

www.gratanet.com

Хуулийн этгээд татан буугдах үйл ажиллагаа

Монгол Улсын Бүртгэлийн байгууллагын 10-р сарын тоон мэдээгээр 2021 оны 10-р сард нийт 67 хуулийн этгээд татан буугдсан байна.

Хуулийн этгээдийн бүртгэл	2020.1-X	2021.1-X	2021.X
Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд	726	337	67 ¹

Хуулийн этгээдийг дараах үндэслэлээр татан буулгана:

- өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан;
- дампуурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;
- үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан;
- хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;
- хуульд заасан бусад үндэслэл.

Хуулийн этгээдийн өөрийн өмчлөгч, эрх бүхий байгууллагын сайн дураар татан буугдах шийдвэр буюу дээр заасан (a),(c),(d) тохиолдолд татан буугдах үйл ажиллагаа нь дараах байдлаар явагдаж болно:

Татан буугдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага татан буугдах ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс нэг сарын өмнө санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэнэ.

Татан буулгахаар шийдвэр гаргасан байгууллага Татан буулгах комисс томилно. Татан буулгах комиссыг томилсноор тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.

¹ <https://burtgel.gov.mn/post/59241>

III

Хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын 15 өдрийн дотор холбогдох улсын бүртгэлийн байгууллагад бичгээр мэдэгдэж, татан буулгах тухай шийдвэрийн эх хувийг мэдэгдэлд хавсаргана. Мөн холбогдох Татварын алба болон Нийгмийн даатгалын хэлтэс (шаардлагатай тохиолдолд, Гаалийн Ерөнхий газарт)-т мэдэгдэнэ.

IV

Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдах тухай зарыг өдөр тутмын сонинд нийтэлж, нийтэд мэдээлнэ

V

Татан буулгах комисс нь компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг Харилцагчдад бичгээр мэдэгдэж, тэдний нэхэмжлэлийг хүлээн авна. Мөн нэхэмжлэл болон өр төлбөртэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ. Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид, хууль буюу дүрэмд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.

VI

Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь харилцагчдын шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдаж, төлбөрийг барагдуулж болно. Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараах дарааллаар хангана:

- бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах, татварын өрийг хураах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр;
- хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал;
- дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага;
- хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр;
- хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;
- хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлс;
- хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.

Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн

дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална.

VII

Татан буулгах комисс нь татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах тухай хүсэлтээ Татварын албанд цахим, эсхүл цаасан хэлбэрээр гаргах бөгөөд татварын алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- татвар төлөгчийн татварын эрсдэлийг тооцож, эрсдэлтэй тохиолдолд татварын хяналт шалгалтад хамруулна;
- татварын өр, илүү үлдэгдлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ;
- татан буулгах тухай эрх бүхий байгууллага, гишүүдийн шийдвэр, шүүхийн шийдвэр, хяналт шалгалт, эрсдэлийн тооцооллын баримт бичиг, данс хаасан тухай мэдээлэл, санхүүгийн хаалтын тайлан зэрэг мэдээллийг бүрдүүлж хувийн хэрэгт хадгална;
- “Татвар төлөгчийн хасалтын карт”-ыг хөтлөн, уг шийдвэрийг хянан баталгаажуулж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (Улсын бүртгэлийн байгууллага) –д хүргүүлнэ;
- татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан тухай татвар төлөгчид мэдэгдэнэ.

Дээр заасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй, татвар төлөх үүрэг дуусгавар болоогүй тохиолдолд “Татвар төлөгчийн хасалтын карт”-ыг хөтлөхгүй.

Улсын бүртгэлийн байгууллага нь “Татвар төлөгчийн хасалтын карт”-ыг үндэслэн хуулийн этгээдийг бүртгэлээс хасна.

VIII

Татан буулгах санхүүгийн тайлан бэлдэж хувьцаа эзэмшигч, түүний төлөөлөгчөөр батлуулна.

IX

Холбогдох шаардлагыг хангасны дараа Татан буулгах комисс Дуусгалтын тайлан бэлдэж Дуусгалтын тайланг Аудитын шалгалтаар оруулна.

X

Дуусгалтын тайланг харьяа дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэсээр тамга/тэмдэг/ даруулж баталгаажуулна.

Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

- Дуусгалтын тайлан;
- Аудитын шалгалтын дүгнэлт;
- Татвар төлөгчийн хасалтын карт: болон
- Улсын Бүртгэлийн Гэрчилгээний хуулбар

XI

Хуулийн этгээдийн банкны дансыг хаана.

XII

Архивын байгууллагад өргөдөл өгч дараах баримт бичгийг тушаана:

- Дүрэм, үүсгэн байгуулах шийдвэр, Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл;
- Хувьцаа эзэмшигчийн шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл;
- Санхүүгийн тайлан, аудитын шалгалтын тайлан;
- Нягтлан бодох бүртгэлийн баримтууд;
- Хүний нөөцийн баримт бичиг.

XIII

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас өр, төлбөртэй эсэх лавлагаа авна.

Лавлагаа авах өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

- Хуулийн этгээдийн Улсын Бүртгэлийн Гэрчилгээний хуулбар
- Лавлагааны хураамж – 10 000 төгрөг /3.5 ам.доллар/

XIV

Улсын бүртгэлийн байгууллагад тамга, тэмдгээ хураалгана.

XV

Татан буулгах комисс дараах баримт бичгийг бүрдүүлж, Улсын Бүртгэлийн байгууллагад хандана.

- Өргөдөл УБ-03;
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт (Улсын тэмдэгтийн хураамж - /10,000 төгрөг /3.5 ам.доллар/ ГХО-тай хуулийн этгээд - 40,000 төгрөг /14 ам.доллар/)

- Улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/;
- Татан буулгасан тухай зарлуулсан өдөр тутмын сонин;
- Компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн шийдвэр /тогтоол/ /толгой компанитай бол түүний хувьцаа эзэмшигчдийн шийдвэр/ тогтоол /1 эх хувь/;
- Дуусгалтын тайлан;
- Татвар төлөгчийн хасалтын карт;
- Тамга, тэмдэг хураалгасан баримт /1 хувь/;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа;

Дээрх баримт бичгийг Улсын бүртгэлийн байгууллага хүлээн авч татан буугдсан хуулийн этгээдийн тухай мэдээллийг ажлын 5 хоногт улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулснаар тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассанд тооцож татан буугдах үйл ажиллагаа дуусгавар болно. Улсын Бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийг бүртгэлээс хассан тухайгаа цахим хуудсаар нийтэд тухай бүр мэдээлнэ.

Хуулийн этгээдийг татан буулгах дээрх үйл ажиллагааны алхмуудын зарим нь дараалал солигдох болон бусад шаардлагатай нэмэлт алхмуудыг хийж болно. Тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, хөрөнгө болон өр авлагын байдлаас хамаарч, татан буулгах үйл ажиллагааны зарим ажиллагаа саатах, тодорхойгүй хугацаагаар хойшилж болно.

Хуулийн этгээдийн татан буугдах ажиллагаа нь 6 сараас 1 жил ба түүнээс удаан хугацаанд үргэлжилдэг.

Эх сурвалж:

<https://legalinfo.mn/mn/detail/299> - Иргэний хууль

<https://legalinfo.mn/mn/detail/310> - Компанийн тухай хууль

<https://legalinfo.mn/mn/detail/14403> - Татварын Ерөнхий хууль

<https://legalinfo.mn/mn/detail/11192> - Аудитын тухай хууль

<https://legalinfo.mn/mn/detail/13591> - Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн тухай хууль

<https://legalinfo.mn/mn/detail/15197/2/210825> - Татвар Төлөгчийн Бүртгэлийн журам

<https://legalinfo.mn/mn/detail/13807/2/208819> - Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал GRATA Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн bvolodya@gratanet.com болон Туслах хуульч Г.Солонго sgansukh@gratanet.com хаягаар эсвэл 976 70155031 утсаар холбоо барина уу.

Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм GRATA Интернэшнлийн Монгол дах оффис болох Өмгөөллийн “GRATA Интернэшнл Монголиа” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэсэн. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Энэхүү хууль зүйн мэдээллийг уншигч нь ямар нэгэн үйлдэл хийхээсээ өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.